

## ГЛОБАЛЧЛАЛЫН ЭРИНИЙ ОРОСЫН ЭДИЙН ЗАСАГ

Ц.Баатар\*

Социалист систем нуран унаснаас хойшхи сүүлийн 15-17 жилийн хугацаанд пост коммунизмын орнуудын шилжилт ямар замаар явж, ямар туршлага сургамж хуримтлуулав. Одоо тэдгээр орнуудын шилжилтийн эдийн засаг ямар байдалтай байна вэ гэх мэт олон асуултад хариулах, нийтлэг жишээ татах орон бол ОХУ гэж үзнэ.

Дэлхийн бодлогод ихээхэн жин нөлөө бүхий том гүрний нэг ОХУ. Тийм ч учраас энэ агуу том Орос гүрний эдийн засгийн өрнөл хөгжлийн асуудал дэлхий нийтийн анхаарлын төвд байнга байдаг. Монгол Улсын эдийн засаг нийгмийн амьдралд Оросын хүчин зүйл томоохон байр суурь эзэлдэг. Мөнхийн хөрш, олон жилийн уламжлалт найрсаг харилцаатай явж ирсэн, саяхан стратегийн түнш болсон Орос орны шилжилтийн эдийн засгийн хөгжлийн тоймыг Оросын статистикийн мэдээ, бусад сурвалжуудыг ашиглан энэхүү бэсрэг өгүүлэлд тоймлон авч үзэх оролдлого хийлээ.

Орос орны хөгжлийн өнөөгийн үйл явц ээдрээ төвөгтэй ч гэсэн урагшилсаар байна. Эдийн засгийн глобалчлалын өнөөгийн эринд Орос улс глобалчлалын талбарт багтаж байгаа эсэх нь бас л олон нийтийн анхаарал сонирхол татсан асуудлын нэг яах аргагүй мөн. Тийм гэж хариулах боломжийг олон зүйл харуулж байгаагийн дотор юуны түрүүнд өөрчлөн байгуулалт, бүтцийн өөрчлөлт шинэчлэлт өрнөсөн сүүлийн 15 жилд гарсан гайхамшигт өөрчлөлтүүд, өрнөдөд үл итгэх бодлогоос татгалзаж, 25 жилийн өмнө бол огт санаанд багтамгүйгээр 2001 оны есдүгээр сарын 11-ний алан хядах ажиллагааны дараа өрнөдтэй нягт хамтран ажиллах шийдвэр гаргасан зэрэг явдлууд энд орж байна. Орос хэлбэртэй глобалчлалын гадаад шинж тэмдэг их байна. Энэ нь наад зах нь Москва, Санкт-Петербургт тогтож буй амьдралын стандартаас харж болох ажээ.

Гэсэн хэдий ч гадна шинж тэмдэгүүдийн цаана Орос болон өрнөдийн хооронд мэдэгдэхүйц гүн ялгаа байгааг анзаарахгүй байж болохгүй биз ээ. Тэдгээрийн дотор хэрэглээний технологийг олон нийт хоцронгүй хүлээн авч байгаа болон ихэнхи нутаг дэвсгэрт ялангуяа төвөөс алслагдсан бүс нутагт амьдралын ялгаа өрнөдийн хэв маягаас ихээхэн ялгаатай байгаа хийгээд харилцаа холбооны болон бусад таагүй нөхцлийн ихээхэн тулгамдсан асуудлууд орж байна. Орос орон дэлхийн глобалчлалын

\* Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

талбарт багтахгүй байгааг хамгийн тодоор гэрчилж буй зүйл бол 2001 онд ДНБ-ий үйлдвэрлэлийн уналт дэлхий нийтийг хамарч, АНУ, Европын Холбооны ихэнх орон болон Японд хүртэл ажиглагдаж байхад Орос ДНБ-ий өсөлт 5 орчим хувьтай байсан явдал юм. Өөрөөр хэлбэл Оросын эдийн засгийн хөгжил нь дэлхийн аж үйлдвэржсэн тэргүүлэх гүрнүүдийн эдийн засагтай интеграцчлагдаагүй, харилцан хамаарал бараг байхгүй байгааг нотолж өгсөн юм. Түүгээр ч үл барам энэ нь хөгжингүй орнуудын хөгжлийн үйл явцаас эсрэг байрлалд оршиж байгааг харууллаа.

Дэлхий нийтэд мэдээллийн үнэ цэнэ өсөх үйл явц өрнөж байхад өргөн уудам газар нутагтай Орос оронд энэ салбар хангалттай хэмжээнд хүрээгүй байгаа ч сүүлийн хэдэн жилд интернет болон мэдээллийн бусад сүлжээ үсрэнгүй хөгжсөн билээ. Гэхдээ мэдээлэлжүүлэлтийг улсын хэмжээнд авч үзвэл Оросын мэдээллийн салбар хөгжингүй орнуудын түвшинд хүрэх яагаа ч үгүй байгааг судлаачид тэмдэглэж байна.

Энэ бүхнээс үзэхэд Орос орон хөгжингүй болон бусад улс оронтой олон мянган шижмээр холбогдсон хэдий ч арай өөр хоёрдмол шинжтэй орон зайд оршиж байна гэж үзэж болох юм.

### **Оросын эдийн засгийн шилжилтийн өнөөгийн байдал, чиг хандлага**

Орос орон шинэтгэлийн явцад тус орныг дэлхийн аж ахуйд чамгүй интеграцчилж, энэ чиглэлээр зөвлөлтийн дараахи орон зайд түүнийг идэвхитэй оролцуулах стратеги баримталж байна. Энэ зам нь нэлээдгүй ээдрээтэй түвэгтэй, хүнд хэцүү зам туулж ирлээ. Шилжилтийн эдийн засгийн хямралыг туулж байгаа орон дэлхийн эдийн засагт зохих байр сууриа богино хугацаанд эзлэх гэдэг мэдээж амаргүй хүнд сорилт. Гэсэн хэдий ч хоёр тив дамнасан газар зүйн нэн тааламжтай байрлал, байгалийн арвин их баялаг, шинжлэх ухаан-оюуны болон аж үйлдвэрийн үлэмжхэн чадавхи зэрэг асар их боломжийг харгалзан үзвэл, дэлхийн эдийн засагт Оросын гүйцэтгэх үүрэг роль богино хугацаанд өсөн нэмэгдэх магадлал өндөр.

Шилжилтийн эдийн засагтай энэ том гүрний макро эдийн засгийн гол гол үзүүлэлтийг авч үзье. Юуны өмнө ер нь Орос орон дэлхийн бүтээгдэхүүний хувьд тийм их биш. Тухайлбал, 1990 онд 5.5, 2001 онд 2.7 хувийг эзэлж байв. Энэ дотоодын үйлдвэрлэл хүндрэлтэй хэвээр, өрсөлдөх чадвар төдий л ахиагүй болохыг харуулж байна. Үүнийг хүснэгт 1-ээс үзнэ үү.

### Хүснэгт 1. Дэлхийн бүтээгдэхүүнд Оросын эзлэх хувь хэмжээний өөрчлөлт (1990-2001)

	Россия		Весь мир		Доля России в мировом выпуске, %
	млрд. долл. <sup>1</sup>	темп роста, % <sup>2</sup>	млрд. долл. <sup>1</sup>	темп роста, % <sup>3</sup>	
1990	1661	97.0	30204	102.7	5.5
1991	1578	95.0	30748	101.8	5.1
1992	1349	85.5	31363	102.0	4.3
1993	1232	91.3	32084	102.3	3.8
1994	1075	87.3	33271	103.7	3.2
1995	1031	95.9	34469	103.6	3.0
1996	996 <sup>c</sup>	96.6	35848 <sup>d</sup>	104.0	2.8
1997	1005	100.9	37354	104.2	2.7
1998	956	95.1	38400	102.8	2.5
1999	1007	105.4	39782	103.6	2.5
2000	1091	108.3	41652	104.7	2.6
2001	1146	105.0	42651	102.4	2.7

Эх сурвалж: <sup>1</sup> В ценах 1996 г.

<sup>2</sup> Российский статистический ежегодник 2001 г., на основе программы международных сопоставлений

<sup>3</sup> World Economic Outlook, October 1998, May 1999, May 2000, December 2001

<sup>4</sup> Расчет на основе данных Российского статистического ежегодника 2001 г. Handbook of International Economic Statistics: Central Intelligence Agency, Directorate of Intelligence.

Үндэсний валютын ханшны байдал, газар нутаг, хүн ам, дэлхийн бүтээгдэхүүний гаргалтад хэдэн хувь эзэлдэг болохыг 2,3-р хүснэгтээс үзнэ үү. Оросын валютын ханш сул хэвээр байгаа нь эндээс харагдана.

### Хүснэгт 2. Үндэсний валютын ханш худалдан авах чадвар (1999)

США	1.00
Япония	1.42
Германия	1.04
Великобритания	1.05
Франция	1.04
Россия <sup>2</sup>	0.30

### Хүснэгт 3. Газар нутаг, хүн ам, бүтээгдэхүүний гаргалт (хувиар)

	Удельный вес		
	территории <sup>1</sup>	населения <sup>1</sup>	выпуска <sup>2</sup>
США	7.0	4.7	20.6
Япония	0.3	2.1	8.4
Германия	0.3	1.4	4.9
Великобритания	0.2	1.0	3.2
Франция	0.4	1.0	3.3
Россия	12.8	2.4	2.8


Оросын макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт сүүлийн таван жилд ямар байгааг дараах хүснэгтээс үзнэ үү.

### Хүснэгт 4. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд (хувиар)

	2001	2002	2003	2004	2005, оценка
Инфляция, декабрь к декабрю	118.6	115.1	112.0	111.7	110
Валовой внутренний продукт	5.1	4.7	7.3	7.1	6.2
Продукция промышленности <sup>1</sup>	4.9	3.7	7.0/7.8	6.1/7.0	5.6 <sup>2</sup>
топливно-энергетические отрасли	4.4	4.2	6.5/6.5	4.9/4.9	3.3
сырьевые отрасли	3.3	3.3	5.9/7.1	4.8/6.3	4.6
машиностроение	7.1	1.9	9.2/9.2	11.7/11.7	10.4
потребительские отрасли	8.0	5.5	4.4/7.6	3.0/7.0	6.2
Продукция сельского хозяйства	7.5	1.5	1.3	1.6	-
Реальные располагаемые денежные доходы населения	8.7	11.3	14.9/9.7 <sup>3</sup>	8.2	8.6
Оборот розничной торговли	11.0	9.3	8.4	12.1	8.8
Инвестиции в основной капитал	10.0	2.8	12.5	10.9	10.1
Мировая цена на нефть (Urals), долл. за баррель	23.0	23.7	27.2	34.5	37.0
Экспорт товаров, млрд. долл.	101.9	107.3	135.9	183.2	200
в % к ВВП	33.2	31.1	31.6	31.5	27.8
в реальном выражении	3.1	8.9	9.6	10.8	4.3
Импорт товаров, млрд. долл.	53.8	61.0	76.1	94.8	109
в % к ВВП	17.5	17.7	17.7	16.3	15.2
в реальном выражении	21.5	9.9	19.3	21.0	17
Сальдо торгового баланса, млрд. долл.	48.1	46.3	59.6	87.3	91

Сүүлийн 2 жилийн макро эдийн засгийн үзүүлэлтийг графикаар харуулбал дараах дүр зураг гарч байна.

**График 1. 2003 оны макро эдийн засгийн үзүүлэлтийг 2004 онтой харьцуулсан байдал**



Хүснэгт 4, график 1-д харуулсан үзүүлэлтүүд нь Оросын макро эдийн засгийн төлөв байдлыг ямар нэг тайлбаргүйгээр харуулна гэж бодож байна.

Оросын эдийн засагчид тус орны эдийн засгийн өсөлт хөгжлийн ойрын ирээдүйн дүр төрхийг 3 хувилбараар авч үзсэн байна. Энэхүү таамаглалаас үзэхэд аль ч хувилбараар нь үзсэн эдийн засгийн өсөлт тогтвортой хөгжлийн замд орох өөдрөг шинж төлөв харагдаж байна. Үүнийг дараах хүснэгтээс үзнэ үү.

**Хүснэгт 5. Оросын эдийн засгийн өсөлт /хувиар/**

	ВВП России, млрд. долл. в ценах 1996 г.			Мировой выпуск, млрд. долл. в ценах 1996 г.	Темп роста мирового выпуска, % <sup>1</sup>
	I (средний темп роста 101.5%)	II (средний темп роста 103.0%)	III (средний темп роста 107.0%)		
2002	1163	1180	1226	43376	101.7
2003	1180	1215	1312	44840	103.4
2004	1198	1252	1403	46208	103.1
2005	1216	1289	1502	47571	103.0
2006	1234	1328	1607	48939	102.9
2007	1253	1368	1719	50312	102.8
2008	1271	1409	1840	51687	102.7
2009	1291	1451	1968	53065	102.7
2010	1310	1495	2106	54445	102.6
<b>Доля России в мировом выпуске в 2010 г. %</b>	<b>2.4</b>	<b>2.7</b>	<b>3.9</b>		

<sup>1</sup> 2002-2005 гг. - оценка на основе прогноза Минэкономразвития РФ

Бид дээр Оросын макро эдийн засгийн гол гол үзүүлэлттэй танилцлаа. Одоо бид Орос орны эдийн засгийн өсөлт хөгжлийн зүтгүүр нь болоод буй гадаад эдийн засгийн харилцааны өнөөгийн байдал болон Орос орон олон улсын хөдөлмөрийн хуваарьт хэрхэн оролцох чиг хандлагатай байгааг авч үзье.

**Гадаад худалдааны динамик.** Орос улс дэлхийн эдийн засаг дахь хувийн жингээрээ хуучин Зөвлөлт Холбоот Улсаас нэлээд дутуу нь ойлгомжтой. Тодруулбал, Орос холбооны улсынхаа хувьд хэдийгээр хамгийн том бүгд найрамдах улс нь хэдий ч, ЗСБНХУ тарж бутарсаны дараа үүсч бий болсон тусгаар улсуудын зөвхөн нэг л юм. Улс орныг хорин таван жилээр гэдрэг ухраасан эдийн засгийн тогтолцоо огцом нурснаар XXI зууны эхээр дэлхийн ДНБ-ий 3 хүрэхгүй хувь нь Орост ногдож байв. 2000-2001 онд гадаад худалдааны эргэлтийн хэмжээгээр тус улс Швед, Норвеги зэрэг тийм жижиг улсуудын хавьд 20-21 дүгээр байр эзэлж байв.

1990 оныхтой харьцуулбал Оросын гадаад худалдааны эргэлтийн жинхэнэ хэмжээ барагцаалбал хоёр дахин багасч, бараа таваарын бүтэц нь үлэмжхэн муудсан юм. Харамсалтай нь, 1992 онд эрс шинэтгэл хэрэгжүүлж эхэлмэгц үйлдвэрлэл бүхэлдээ асар их унаж, хуучин ЗСБНХУ-ын нутагт болон Оросын өөрийнх нь дотоодод бүрэлдэж бий болсон аж ахуйн харилцаа тасарсан нь гадаад худалдааны эргэлт хумигдахад хүргэхгүй байж чадаагүй билээ. 1991 онд бусад холбооны бүгд найрамдах улстай хийсэн худалдааны бараа эргэлт дэлхийн үнээр тооцоолбол 138 тэрбум ам.доллар, дэлхийн бусад хэсэгтэй хийсэн худалдаа 95 тэрбум ам.доллар байв. Тийнхүү Оросын гадаад худалдааны эргэлтийн динамикт дүн шинжилгээ хийхэд барагцаалбал 233 ам.тэрбум долларыг үндэс болгох хэрэгтэй аж. (Внешняя торговля и предпринимательство России на рубеже XXI .М., 2000 хууд. 29-ийг үзнэ үү)

Шинэтгэлийн эхний хоёр жилд гадаад худалдааны эргэлт эрс унасныг 6-р хүснэгтийн тоо баримт харуулж байна. Энэ үед Оросын ДНБ 1991 оныхоос барагцаалбал 30%-иар буурсан байхад, гадаад худалдааны эргэлт хоёр дахин, хуучин холбооны бүгд найрамдах улсуудтай хийсэн худалдааны эргэлт гурав дахин багассан аж. Цаашид 1994-1997 онд экспорт, импорт жигд биш ч гэсэн бага зэрэг нэмэгдэж, гэхдээ импортын өсөлтийн хурдац нэлээд доогуур байжээ.

**Хүснэгт 6. Оросын гадаад худалдааны хэмжээ,  
тухайн жилүүдийн үнээр, тэрбум ам.доллар**

Он	Экспорт	Импорт	Сальдо
1992	53.6	43.0	10.6
1993	59.7	44.3	15.4
1994	67.8	50.5	17.3
1995	82.9	62.6	20.3
1996	90.6	68.0	22.6
1997	89.0	72.0	17.0
1998	74.9	58.0	16.9
1999	75.7	39.5	36.2
2000	105.5	44.9	60.6
2001	103.0	53.4	49.6
2002	105.8	46.0	59.8

*Эх сурвалж: Зохих жилүүдийн ОХУ-ын  
статистикийн хорооны тоо баримт.*

Дээр дурдсан тоо баримтуудад ганзагын наймаачдын хийсэн барааны эргэлтийн тэр хэсэг, үнэлгээг оруулан тооцжээ. 1999-2001 онд тэд жил бүр 10 тэрбум ам.долларын бараа импортлож байжээ.

Шилжилтийн явцад Оросын худалдааны баланс чамгүй активтай байсан бөгөөд 2000 онд энэ актив хамгийн дээд түвшин-бараг 60 тэрбум ам.долларт хүрсэн аж. Тухайн үед ОХУ-ын Засгийн газар гадаад өрийн төлбөр хийхээс татгалзах хэмжээнд хүртэл эдийн засаг уналтад орсон байв. Тухайлбал, рублийн ханш дөрөв дахин буурахад хүргэсэн 1998 оны санхүүгийн хямрал энэ үед тохиов. Эдийн засгийн уналтыг дагалдаад импорт эрс буурсан нь экспортлогчдоод бага ч гэсэн боломж нэмэлт хүчин түлхэц болсон байна. Экспортлогчид доллараар тооцоолоход өмнө нь гаргаж байсан хэмжээний экспортоор 2-4 дахин их рублийн орлого олох болжээ. Энэ нь эргээд импортлох сонирхлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болсон байна. Уналт саарч, санхүүгийн хямралыг гэтлэн давах тэр хэмжээгээр эдийн засаг сэргэж, аажмаар хүн амын орлого нэмэгдэх тутам импортын илүү чанартай бүтээгдэхүүний эрэлт ихсэж, эх орны үйлдвэрийн болон гадаадын бараа таваарын үнийн ялгаа арилснаар 2001 оноос импорт дахин өсч эхэлжээ.

Экспорт нь импортоосоо олон жилийн турш ихээхэн давж байсныг тайлбарлах шаардлагатай. Япон болон ЕХ-ны хувьд ч мөн ийм. Бусад тэгш нөхцөлд энэ нь улс орны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний нэг хэсгийг өөрөө хэрэглэдэггүй, импортын төлбөр хийхэд зарцуулдаггүй, харин гадагш гаргаж байна гэсэн үг юм. Олсон зохих валют нь төв банкны валютын нөөцийг сэлбэх, гадаад өр төлөхөд ашиглагдаж, үнэгүйжихээс

баталгаатай хамгаалуулсан нөөцийн хувиар үйлдвэр болон хувь хүмүүсийн гадаад дахь банкны дансанд орж, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө болгож, үйлдвэрийн объект барих юмуу худалдан авахад зориулж байна. Тийнхүү жишээлвэл, Оросын төв банкны алт-валютын нөөц 1997 онд 12 тэрбум ам.доллар байсан бол, 2002 онд 37 тэрбум ам.долларт хүрчээ. Гадаадад оруулсан хөрөнгө нь тодорхой орлого оруулж байгаа ч, Оросын хувьд энэ нь гадаадад гарсан мөнгийг дотоодын үйлдвэрлэлд ашиглаж олсон орлогоос хавьгүй бага юм. Гэсэн ч Орос улс хөрөнгө оруулалтын өлсгөлөн, ажилгүйдлийн зовлон бэрхшээлийг тойрсонгүй.

Хэд хэдэн шалтгаанаас болоод экспортын нийлүүлэлт онцгой ашигтай болж, экспорт дотоодын зах зээлд худалдаалахаас одоохондоо илүү дээр байна. Инфляци их байгаа нөхцөлд хатуу валютаар худалдаалах нь орлогыг үнэгүйжихээс хамгаалж байна. Эцэст нь, экспорт эдийн засгийн үйл ажиллагаа, хүн амын орлого хоёр дахин багассанаас болоод эрэлтгүй болсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих цорын ганц боломж болсон хэвээр байна.

**Гадаад худалдааны таваарын бүтэц.** Орос орны гадаад эдийн засгийн харилцааны гол цөм нь өнөө хэр түлш-түүхий эдийн бүлгийн бараа таваар, металл, бордоо, модон материал зохилсон хэвээр байна. Машины үйлдвэрийн (цэрэг, батлан хамгаалахын зэвсэглэлээс бусад) болон зарим төрлийн бэлэн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлийн өрсөлдөөнийг даах юмуу, Оросын бараа таваарт өрнөдийн орнуудын тавьж буй хаалт хоригийг хараахан давж чадахгүй байна. Жишээ нь ган цувимал, бусад металл, баяжуулсан уран, химийн үйлдвэрийн бараа таваар, шил, мод-нийлэг хавтан зэрэг Оросын өрсөлдөх давуу талтай бүтээгдэхүүнүүд ямар нэг хязгаарлалттай тулгарч буй аж. Энэ нь ОХУ Дэлхийн худалдааны байгууллагад өнөө хэр элсээгүй, ганцаарчилсан тоглолт хийж ирсэнтэй ч зарим талаар холбоотой.

2000 онд тус оронд олборлосон нефтийн 45%, байгалийн хийн 35%, нефтийн бүтээгдэхүүний 36%, хар металлын бэлэн цувималын 23%, үйлдвэрлэсэн эрдэс бордооны 81%, боловсруулаагүй модон материалын 39%, целлюлозын 84%-ийг тус тус экспортод гаргаж байв. 2000 онд гадаад орнуудад экспортын нийт өртгийн 87%, түүний дотор аж үйлдвэр хөгжсөн орнуудад 65% орчим, хөгжиж буй орнуудад 22%, харин хуучин зөвлөлтийн бүгд найрамдах улсуудад 13% нь ногдож байсныг хэлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, Оросын экспорт нь үндсэндээ Өрнөд Европ (3/2 гаруй), Төв болон Зүүн Европ, АНУ-ыг баримжаалж байна гэсэн үг. 2000 онд Оросын худалдааны түншүүдийн дотроос гадаад худалдааны эргэлтийн хэмжээгээр



эхний байранд Герман, хоёрт Итали, гуравт АНУ, дөрөвт Хятад орж байв. Гадаад харилцааны чиг баримжаа өөрчлөгдөх явцад Төв болон Зүүн Европын орнуудтай хийх худалдаа эрс багасчээ.

Шилжилтийн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих бараг л цорын ганц хүчин зүйл хэвээр байгаа Оросын экспортод байгалийн эрдэс бүтээгдэхүүн болох хий, нефть, металл, бордоо, модон материал зонхилж байна. Эдгээр нь экспортын бүх орлогын 4/3 гаруйг бүрүүлдэг аж. 90-ээд оны дундуур Орос улс хөнгөн цагааны экспортоор дэлхийд эхний байр, хар металл экспортлогчдын дотор хоёрдугаар байранд орох болсон. Дэлхийн хөнгөн цагааны экспортын 25%, никелийн 20, зэсийн 7% (МЭ и МО сэтгүүл, 2001. №3, хууд. 24-ийг үз) нь Орост ногдож байв.

Энэ хугацаанд гадаадад нефть нийлүүлэлт багахан (14%) өсч, харин хий, нефтийн бүтээгдэхүүний экспорт 5%-иар буурч, гэхдээ төмрийн хүдэр, түүний концентрат, нүүрс, бордоо, гуалин, фанер, целюз, ширэм нийлүүлэлт 1,5 болон үүнээс илүү дахин, түүнчлэн хөнгөн цагаан, зэс, никелийнх 20%-иар нэмэгдсэнийг 1996-2000 оны экспортын жинхэнэ хэмжээний өсөлтийн тоо баримт харуулж байна. Гэхдээ энэ нь экспортын орлого ч зохих хэмжээгээр өссөн гэсэн хэрэг биш бөгөөд учир нь дээр дурдсан олонхи барааны (түлшнээс бусад) экспортын үнэ мөн энэ хугацаанд 20-25%-иар унасан аж. (Оболенский В.П. Конкурентные возможности России и перспективы перестройки ее внешней торговли (эрдэм шинжилгээний илтгэл М., 2001. Хууд.43-ыг үз).

### Хүснэгт 7. 2000 оны Оросын экспортын таваарын бүтэц

Экспортын зүйл	Нийт	Экспорт	Хуучин холбооны	Гадаад
	Тэрбум.\$	Хувь,%	БНУ-дад Хувь, %	орнуудад Хувь, %
Эрчим хүч агуулагч - түүний дотор:	54,2	52,7	38,2 (1)	25,0 (1)
Байгалийн хий	16,6	16,1		
Түүхий нефть	25,3	24,6	25,8	17,1
Нефтийн бүтээгдэхүүн	10,8	10,5	11,2	5,8
Нүүрс	1,1	1,1	1,1	1,1
Металл	18,7	18,2	19,7	8,1
Машин, тоног төхөөрөмж	9,2	8,9	7,7	17,3
Химийн бүтээгдэхүүн	2,4	2,3	2,5	1,0
Модон материал	3,7	3,6	3,6	3,4
Бусад бараа	14,6	14,2	28,2	45,2
Бүгд	102,8	100,0	100,0	100,0

Эх сурвалж: *Обзор экономики России. 2001. №1 (31). Хууд. 160, 163; Рабочий центр экономических реформ при Правительстве РФ. Российско-европейский центр экономической политики. М., 2001.*

Дээр нэгэнт өгүүлснээр, Оросын экспортын түлш-түүхий эдийн чиг баримжаа нь зохих салбаруудыг дутуу ачааллаас ангижруулж, нийт эдийн

засгийг болзошгүй уналтад орохоос хамгаалах зэрэгт чухал үүрэг гүйцэтгэж байгаа тул нэг хэсэгтээ л ийм бүтэцтэй байхаас аргагүйг Оросын эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг. Гэвч дэлхийн нийтлэг хандлагатай таарахгүй байгаа бүтцийн энэ байдал удаан үргэлжилбэл үндэсний эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхийг судлаачид анхааруулж ирлээ. Улс орны төсвийн болон өрийн асуудлыг шийдвэрлэх ид шидийн савааны хувиар дулааны цахилгааны цогцолбор салбаруудад найдлага тавьж байгаа нь боловсруулах салбарууд болон хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборын хөгжлийн боломжийг хязгаарлаж байна. Үйлдвэрлэж буй бордооны 5/4-ийг гадаадад гарган, Оросын хөдөө аж ахуйд хохирол учруулж байгаа нь зах зээлийн шинэтгэлээс үүдэлтэй гаж бүтцийн үр дагаварын нэг аж.

Дотоодын үнэ нь хэд хэдэн тохиолдолд дэлхийнхээс дээгүүр бөгөөд эх орны хэрэглэгчдийн бэл бэнчин нь хүрэхгүй байгаа олон төрлийн өнгөт металлын экспорт нь мөн ийм гаж бүтцийн нэг гэнэ. Үүнээс болж боловсруулах салбарууд хохирч байна. Metallурги, суурь хими, целлюлоз-цаас, цементийн зэрэг салбарууд хэт хөгжсөнөөр эдийн засгийн нүсэр бүтэц бий болж буй нь хүрээлэн байгаа орчныг үлэмжхэн бохирдуулж буй хамгийн уршигт үр дагавартай болохыг шинжээчид анхааруулж байна.

Машин, тоног төхөөрөмжийн тухайд гэвэл, экспортод эдгээрийн хувь хэмжээ өчүүхэн бөгөөд оросын аж үйлдвэрийн бий болсон бүтэц, түүний шинжлэх ухаан-техникийн чадавхид нийцэхгүй байна. Дэлхийн экспортод энэ бүлгийн хувийн жин 40%, АНУ, Германы экспортод бараг 50%-д хүрч байхад Орост 10%-д ч хүрэхгүй байгаа аж. Оросын аж үйлдвэрийн боловсруулах салбаруудын гадагш гаргаж буй бүтээгдэхүүнд талаас илүү нь тааруухан технологийн, 40 гаруйхан хувь нь технологийн хувьд жирийн, ердөө 1,5-1,8% нь оюуны багтаамжтай, шилдэг технологийн бүтээгдэхүүн эзэлдэг байна. Цэргийн техникийн экспорт л одоогоор өрсөлдөх чадвартай хэвээр байгаа бөгөөд Орос улс дэлхийн зах зээлийн энэ хэсэгт АНУ, Их Британи, Францын дараа дөрөвдүгээр байранд ордог.

### Хүснэгт 8. 2000 оны Оросын импортын таваарын бүтэц

Импортын зүйл	Нийт	Импорт	Гадаад	орнууд	Хулчин	БНУ-ууд
	Тэрбум \$	Хувь,%	Тэрбум \$	Хувь,%	Тэрбум \$	Хувь, %
Хүсний бүтээгдэхүүн Эн тэргүүний шаардлагатай биш хэрэглээний бараа (1)	3,4	10,1	2,3	10,5	1,1	9,3
Хувцас, тавилга, эм болон бусад	1,0	3,0	0,6	2,8	0,4	3,2
Машин, тоног төхөөрөмж (2)	2,2	6,5	1,4	6,4	0,8	6,7
Бусад бараа	10,6	31,4	8,0	36,2	2,6	22,2
Бүгд	16,7	49,0	9,9	44,1	6,7	58,6
	33,9	100,0	22,2	100,0	11,6	100,0

*Эх сурвалж: Внешняя торговля и предпринимательство  
России на рубеже XXI века. М., 2000, хууд. 51-ийг үз.*

Түүхий эд, түлш, материалыг гадагш гаргах нь ерөөс олон улсын худалдааны хэвийн, практикт байдаг асуудал. Гэвч АНУ, Англи, Австрали, Канад, Норвеги зэрэг тийм хөгжингүй орнуудын экспортод энэ огтхон ч гол байр суурь эзлэдэггүй. Энэ том гүрний экспортын бүтэц ерөөсгөл хандлага нь буурай хөгжилтэй, жижиг шилжилтийн эдийн засагтай Монгол мэтийн хөгжиж байгаа орны гадагш гаргадаг бүтцийг санагдуулж байна гэж Оросын эрдэмтэд тэмдэглээд энэ нь Оросын эдийн засаг дэлхийн зах зээлийн конъюнктурын тогтворгүй байдлаас ихээхэн хамааралтай хэвээр байгааг харуулж байна гэжээ. Улсын төсөв ер нь нийт эдийн засгийн байдал эцсийн бүлэгт дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэлээс шууд хамаардаг аж. Жишээ нь дэлхийн зах зээлд нефтийн үнэ хэрхэн бүрдэж, нэг баррель нь хэд хүрэхээс бүх зүйл хамаарах болжээ. Энэ хараат байдал нь Оросын эдийн засгийн бүтцийг алдагдуулсан бөгөөд учир нь экспортын чиглэлээр ажилладаггүй, дотооддоо хангалттай борлуулалтгүй салбарууд уналтад орж байгаагаар илэрч байна.

90-ээд оны импорт нь хүн амын хэрэглээг тэвчихээс аргагүй түвшинд байлгаж, эмх замбараагүй болсон эдийн засгийн цоорхойг нөхөхөд туслаж байв. Импортын бүтцэд хүнсний бүтээгдэхүүн, түүнийг үйлдвэрлэх түүхий эд, тэрчилэн гутал, хувцас, ахуйн болон бичиг хэргийн техник, тухайлбал компьютер, түүний бүрдэл хэсгүүд, хөнгөн тэрэг, үйлдвэрлэлийн биш зориулалттай янз бүрийн тоног төхөөрөмж зонхилж байв. Барааны энэ бүлэгт импортын нийт өртгийн 50-55% нь ногдож байв. 1998 оныг хүртэл Орост хэрэглэдэг хүнсний барааны тэн хагас орчмыг гадаадаас авчирч байжээ. Рублийн валюттай харьцах ханш навс унасны дараа л жижиглэнгийн барааны эргэлтэд эх орны хүнсний бүтээгдэхүүн болон хэрэглээний барааны эзлэх хувь хэмжээ 2001 онд 60% болж өссөн юм. Гэвч импортын барааны нийт бүтцэд энэ нь бараг нөлөөлөөгүй бөгөөд бүтэц ч зарчмын хувьд өөрчлөгдөөгүй аж.

Нэхмэл эдлэл, хувцас, гутал, жижиг бараа болон ахуйн бусад аар саар барааны дотоодын хэрэгцээг ганзагын наймаачид мэдэгдэхүйц хэмжээгээр хангаж байв. 1997 онд ганзагын наймааны ид үед тэд 7 тэрбум гаруй ам долларын дээр дурдсан барааг оруулж ирсэн байхад, хэвийн худалдааны шугамаар дөнгөж 2 тэрбум ам.долларын бараа оруулж ирсэн мэдээ бий.

Хэрвээ зөвлөлтийн үед импортод машин, тоног төхөөрөмж, барилга-замын техник, иж бүрдэл эдлэхүүн, бүрдэл хэсгүүд зэрэг их хэмжээтэй байсан бөгөөд өөрөөр хэлбэл, энэ импорт үйлдвэрлэлийн тодорхой зориулалттай байсан бол, Оросын зах зээлийн шинэтгэл нь

ихэнхидээ түүнийг хэрэглээний шинж чанартай болгосон байна. Үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт эрс багассан нь нэн шинэ тоног төхөөрөмж оруулж ирэх ажил хумигдах нөхцлийг бүрдүүлсэн билээ. Харамсалтай нь, эдийн засгийн өсөлтийг хурдастана хэмээн шинэтгэлийн талынхны итгэж байсан Оросын эдийн засгийн нээлттэй байдал шинжлэх ухаан-техникийн дэвшлийг хангаж, тус орны үйлдвэрлэлийн баазыг шинэчлэх үр нөлөөтэй хэрэглүүр болоогүй аж.

1998 оны валют-санхүүгийн хямралыг дагалдан, хүн амын бодит орлого үлэмжхэн буурч, импортын барааны үнэ өртөг ихэссэнээс болоод оруулж ирдэг хүнсний бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн хэрэглээний барааны хэмжээ багасчээ. Тухайлбал, ОХУ-ын статистикийн хорооны тоо баримтаар, 2000 онд 1996 оныхтой харьцуулбал, шинэхэн хөлдөөсөн мах 3/1-ээр, цөшгийн тос 40%-иар, гутал бараг 8 дахин бага оруулж ирсэн байна. Одоогийн өрсөлдөөн болон хязгаарлагдмал эрэлтээс болоод удаан хугацаагаар дутуу ачаалалтай ажиллаж байсан Оросын аж үйлдвэр, хөдөө аж ахуй импортын уналтыг үлэмж хэмжээгээр нөхсөн юм.

Орос улс дэлхийн худалдаанд харьцангуй бага оролцож байгаа ч, дэлхийн зах зээлийн ажил төрлийн байдлаас түүний хамаарах хамаарал ер бусын их юм. 2000 онд Оросын ДНБ-ний нийт хэмжээнд импортын эзлэх хувь хэмжээ 24,9%, жижиглэнгийн худалдаанд 39% байв. Мөрдөж буй ханшаар рубльтэй харьцуулсан доллараар импортын өртгийг тооцоолж, импортын рублийн үнэлгээг дотоодын тухайн үеийн үнээр зах зээлийн нөөцтэй харьцуулах замаар элгээр тоо баримтыг гаргаж авсаныг тэмдэглэх байна. Учир нь худалдан авах чадварын хэмжээтэй харьцуулбал рублийн валютын ханшийг маш их доогуур тогтоосон бол, импортын рублийн үнэлгээ нь дотоодын барааны масстай харьцуулахад түүний хэмжээг хиймлээр хэтрүүлж буй тал бий. Гэсэн ч улс орны аюулгүй байдал, хүнсний бараа, эм, бусад зарим барааны найдвартай байдлыг хангах үүднээс авч үзвэл, гадаад хамаарлын байж болох босгыг дэгсдүүлсэн болохыг дурдсан үзүүлэлтүүд харуулж байна.

Дотоодын эдийн засгийн хөгжлийн эмзэг байдал, дэлхийн зах зээл, гадаад худалдаанаас түүний хараат байдал нь үнэ бүрдэлт зэрэг тийм чухал хүрээнд ч илэрч байна. Үндэсний эдийн засгийн бүтцийг үгүйсгэж буй дотоодын үнийг дэлхийн түвшинд хурдавчилан ойртуулах бодлого, баялаг түлш, түүхий эд болон харьцангуй бага цалингийн өгч буй давуу талууд нь эдийн засагт аюултай гажилт, тэнцвэргүй байдалд хүргэсэн байна. Олон бараа, үйлчилгээний дотоодын үнийг бүрдүүлэхдээ

импортын үнийг үндэс болгож, долларыг өртгийн хэмжээ мэтээр баримжаалахдаа, хүн амын гол хэсгийн цалин, тэтгэвэрийг олон улсын жишигт ойртуулах тийш зохих арга хэмжээ аваагүй нь байдлыг бүр ч хүндрүүлж байна.

Ингэснээр эрэлт унаж, бүрнээ амьдрах чадвартай үйлдвэрлэлүүд араас нь хумигдан оров. Оросын эдийн засаг долларжсан нь түүнийг Америкийн санхүүгийн бодлогод уяж өгч байна. Валютын ханшыг рублиэр тооцоолж үзвэл, Орост долларын эргэлт тус оронд эргэлдэж байгаа рублийн хэмжээнээс давж байна. Долларыг бэлнээр нь оруулж ирж байгаа нь гадаадаас авч буй барааны импорттой харьцуулж болохуйцаар импортын томоохон хүчин зүйл болжээ.

Оросын гадаад худалдааг ерөнхийд нь авч үзвэл, тус орон түүхий эд нийлүүлэгч, үйлдвэрлэлийн биш бэлэн бүтээгдэхүүн хэрэглэгчийн тийм ч хүсүүштэй биш байдлаар олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцож байгааг тэмдэглэх боломж олгож байна. Ийм байдал таатай биш бөгөөд учир нь түүхий эдийг бэлэн бүтээгдэхүүнээр солих үнийн нөхцөл дордох тогтвортой хандлага ажиглагдах болов. Үүнийг Оросын практик харуулж байгаа юм.

### **Хүснэгт 9. Оросын гадаад худалдааны нөхцлийн индекс, 1991 = 100**

Он	Экспортын дундаж үнэ	Импортын дундаж үнэ	Худалдааны нөхцөл
1992	87,2	82,1	106,2
1993	81,1	97,8	82,9
1994	83,0	121,9	68,1
1995	96,0	145,3	66,1
1996	104,3	145,6	71,6
1997	192,3	138,0	74,1
1998	86,1	127,4	67,6
1999	79,1	104,7	75,5

*Эх сурвалж: Внешняя торговля и предпринимательство России на рубеже XXI века. М., 2000, хууд. 51-ийг үз.*

*ОХУ-ын улсын статистикийн хороо, улсын гаалийн хорооны тоо баримтыг үндэслэн оны үнийн индексээр тооцоолов.*

9 дүгээр хүснэгтээс үзвэл, 1999 онд экспортын дундаж үнэ 1991 оныхоос бараг 20%-иар буурч, харин импортын үнэ 5%-иар нэмэгдсэн байна. Ингэснээр Оросын хувьд худалдааны нөхцөл барагцаалбал дөрөвний нэгээр дордож, өөрөөр хэлбэл тус улс олж авсан доллар бүрийн хариуд өөрийн илүү их барааг өгөх ёстой болсон байна. 2001-

2002 онд Оросын нефтийн үнэ нэмэгдсэнээр л энэ алдагдлын заримыг нөхөж чадсан байна.

**Өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нөөц.** Одоогоор гаж үзэгдэл, дутагдал байгаа хэдий ч, гадаад эдийн засгийн харилцааны хөгжил Оросыг сэргээн босгож, түүний аж үйлдвэр, хөдөө аж ахуйг шинэчлэхэд тусалж чадах нь дамжиггүй. Энэ нь гэвч тус орныг дэлхийн эдийн засагт идэвхитэй оролцуулах стратеги боловсруулж, тууштай хэрэгжүүлэн, үйл ажиллагааны энэ хүрээг удирдах ажлыг өөрчлөн байгуулж, экспортлогчдыг дэмжих, өөрийн ирээдүйтэй салбаруудыг хамгаалах, импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээ авахыг шаардаж байгаа юм. Улс орон дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварынхаа түвшинг дээшлүүлж, ингэх сайхан утгвар нөхцөл бүхий тэр салбар, үйлдвэрлэлд найдлага тавих талаар Орос орон сүүлийн үед ихээхэн хүчин чармайлт тавьж байна.

Одоогоор экспортын чадавхийг нэмэгдүүлж, хэрэгжүүлэх боломжийн цар хүрээ хязгаарлагдмал хэвээр байна. Орос улс валютын орлогын нэн чухал эх сурвалж болох эрдсийн нөөцөд бас нэг биш жил тулгуурлах бололтой. Тус улс эрчим хүч агуулагч болон бусад төрлийн түүхий эдээр олон орныг бодвол илүү сайтар хангагдсан билээ. Дэлхийн нээн илрүүлсэн нефтийн нөөцийн 13%, байгалийн хийн 36, нүүрсний 12, дэлхийн нефть олборлолтын 15, хийн олборлолтын 31% нь тус улсад ногдож байна. Үүний хамт ашигт малтмал сэргээгддэггүй, шавхагдаж байгаа явдал, эдгээрийг олборлож, тээвэрлэх ажил хөрөнгийн багтаамж, өөрийн өртөг их байдаг нь олборлох салбаруудад үйлдвэрлэл, экспортыг улам бүр саатуулж, хүндийн төвийг эрчим хүч болон материал хэмнэлтэд шилжүүлэхэд хүргэдэг. Тиймээс Оросын нөөцийн чадавхийг өрсөлдөөний мөнхийн, маргаангүй давуу тал гэж үзэх аргагүй юм. Гадаад худалдаанд түүний үүргийн ухаалаг хэмжээнд аажмаар хүргэхийг орос “ах” нар одооноос нарийн тооцоолж эхэллээ. Үүний зэрэгцээгээр, эдийн засгийн зүй зохистой байдлын үүднээс анхдагч түүхий эд, түш, материалын экспортлодог төрлүүдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүний хэлбэрээр гаргах асуудал ч хурцаар тавигдах боллоо.

Орос улс дэлхийн туршлагыг удирдлага болгохдоо, боловсруулах аж үйлдвэрт, ялангуяа шилдэг технологи хэрэглэдэг тэр газарт экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэхийг гадаад эдийн засгийн стратегийнхаа үндэс болгож байна. Шинэтгэлийн жилүүдэд аж үйлдвэрийн үндсэн фондууд шинэчлэгдээгүй, 70%-иар элэгдэж, харин судалгаа шинжилгээ, төсөл-зохион бүтээх чадавхи мэдэгдэхүйц хэмжээгээр алдагдсаныг харгалзан үзвэл, ингэх нь амаргүй. Зарим үнэлгээнээс үзвэл, Оросын боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний

6% нь л дэлхийн зах зээлд өрсөлдөж чадахаар байгаа ажээ. (МЭ и МО. 2001. №3. Хууд.25-ыг үз) Гэвч нэмэлт хүч чармайлт тавьж, санхүүгийн дэмжлэг үзүүлвэл хосгүй технологи, шинэ бүтээлүүдтэй, мэргэжилтэн, өндөр мэргэшилтэй ажилчдын боловсон хүчин, түүнчилэн үйлдвэрлэлийн бааз хадгалагдаж үлдсэн хэд хэдэн үйлдвэрлэлийг дэлхийн түвшинд хүргэх потенциал бий. Ийм боломжийг алдах нь өөрийгөө аж үйлдвэрийн тэргүүлэх орнудаас улам хоцроход хүргэнэ гэдгийг орос ах нар тоцоолж үзэж байна.

Эдийн засгийн глобалчлалын нөхцөлд бусад оронд байдаггүй эдийн засгийн шинэ зүйлсээс оюуны ашиг бий болгож, олж авах боломж нь өрсөлдөх чадварыг дээшлүүлж, олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцсоноос дээд зэргээр ашиг олох шийдвэрлэх хүчин зүйл болж байгаа билээ. Тиймээс төрийн бодлого нь шинжлэх ухаан-техникийн дэвшлийн хамгийн ирээдүйтэй салбаруудад тийм давуу байдал бий болгож, нэмэгдүүлэхэд чиглэж байх нь чухал байна.

Цэрэг-техникийн цогцолбор, нисэх хүчин-сансрын болон атомын салбар, хөлөг онгоцны үйлдвэр, эрчим хүч, машины үйлдвэр, багаж хэрэгслийн үйлдвэр, лазерын техник, биохими, мэдээлэл зүй, программ хангамжийн олон үйлдвэр шилдэг технологи, техникийн тэргүүний шийдлийг тээгч хэвээр байна. Суурь болон хавсарга шинжлэх ухааны хэд хэдэн чиглэл экспортын өрсөлдөх чадавхитай болох юм. Оросын цэргийн техник дэлхийн машины үйлдвэрийн бүтээгдэхүүний зах зээлд амжилттай гарч байгаа жишээ харууллаа. Цэргийн техник нь экспортын хувийн жингээрээ маш даруухан ч гэсэн одоогоор Оросын техникийн чиглэлийн экспортын салбарт тэргүүлсэн хэвээр байна. Оросын пуужингаар гадаадын хиймэл дагуулуудыг сансрын тойрог замд гаргаж буй нь Оросын шинжлэх ухаан, аж үйлдвэрийн боломжийн нэгэн чухал үзүүлэлт бас болж байгаа билээ гэж хэлж болох юм.

Оросын гадаад эдийн засгийн стратеги нь экспортыг эдийн засгийн өсөлтийн гол эх сурвалж болгох төдийгөөр хязгаарлах ёсгүй нь мэдээж. Хүн ам, нутаг дэвсгэр, аж үйлдвэрийн чадавхиараа агуу томоохон орны хувьд дотоодын зах зээлийг хөгжүүлэх, энэ зах зээлд бараа, үйлчилгээний төлбөрийн чадвартай эрэлт, нийлүүлэлтийг нэгэн зэрэг, байнга нэмэгдүүлэх нь шийдвэрлэх ач холбогдолтой. Оросын зах зээл, өрсөлдөөний хөгжилд тулгуурлаж гэмээ нь Оросын аж үйлдвэр дэлхийн худалдаанд зохих байр суурь эзэлж чадна. Аж үйлдвэрийн өрсөлдөх чадвар нь юуны өмнө аж ахуйн механизмын бүх шижимд амжилттай шинэтгэл хийж, төрийн зохицуулагч үүргийг зах зээлийн

өөрөө өөрийгөө зохицуулах явдалтай зохистойгоор хослуулахыг Орос орон эрмэлзэлж байна. Бий болгож буй аж ахуйн механизм хүмүүсийн шинэлэг үйл ажиллагаа, бүтээн туурвих эрч хүчинд аль хэр шижим түлхэц өгч, шинжлэх ухаан, боловсролыг өрнүүлэх, хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлж, мэдээлэл, соёлд нэвтрэх боломжийг хүн амд олгон, энэ үндсэн дээр эдийн засаг, амьжиргааны түвшингийн дээшлэлтийг аль хэр хангаж чадахаар шинэтгэлийн амжилт тодорхойлогдож байна гэж хэлж болох биз ээ.

Экспортыг илүү үр нөлөөтэй болгож, валютын урсгалыг нэмэгдүүлэх төдийгүй, импортын улс ардын аж ахуйн өгөөжийг дээшлүүлэх зорилт Орос орны өмнө тулгарч байна. Улс орныг глобал эдийн засагт улам идэвхитэй татан оролцуулах энэ хоёр тал нь харилцан уялдаатай бөгөөд эдийн засгийн хөгжлийг хурдасгахад захирагдах ёстой. Харин ингэх нь хуучин үйлдвэрлэлийн хүчин чадлыг сольж, шинийг бий болгохын тулд томхон хөрөнгө оруулахгүйгээр боломжгүй билээ. Эдийн засгийн үндсэн фондуудыг шинэчилж, бүрдүүлэхэд шинэтгэлийн жилүүдэд алдсан зүйлийг нөхөхийн тулд гаднаас хөрөнгө татах талаар Оросын засгийн газар ихээхэн чармайлт тавьж байна. Аль ч салбарт нэн шинэ тоног төхөөрөмж, техник импортлож, лицензи, ноу хау олж авахыг ч амьдрал шаардаж байна.

Өөрөөр хэлбэл, Орос улс түүхий эд, түлшийг бэлэн бүтээгдэхүүнээр (ихэнхидээ хэрэглээний зүйлээр) солиход оршиж байгаа олон улсын хөдөлмөрийн хуваариас ялангуяа оюуны багтаамж ихтэй, шилдэг технологийн бэлэн бүтээгдэхүүнийг гол төлөв үйлдвэрлэх хөдөлмөрийн хуваарьт шилжих зорилт тавьж байна

Өндөр технологи, шинэ техник оруулж ирэхийг хөхиүлэн дэмжиж, гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, импортын зохисгүй хараат байдлыг багасгах боломж олгох өөрийн үйлдвэрлэлийг хамгаалах үүрэг төрд ногдож байна. Гадаад эдийн засгийн бүхий л арга хэрэгслийг (гаалийн татвар, зээл, даатгалын болон татварын хөнгөлөлт, эрх зүйн зохицуулалт, захиргааны дүрэм журам) эдгээр зорилгод нийцүүлэх хүчин чармайлт тавьж байна. Харамсалтай нь, зах зээлийн эрс шинэтгэл эхлэснээр гаалийн татвар болон татварыг ихэнхидээ эдийн засгийн хувьд тохиромжтой импорт, экспортод нөлөөлөх хэрэгсэл биш, харин төсвийн орлогын эх үүсгэвэр хэмээн үзэх болсон. Түүгээр ч барахгүй, Оросын элсэхээр эрмэлзэж байгаа ДХБ-ын шахалтаар гаалийн хамгаалалтыг бууруулсан нь Оросын нутагт бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах биш,



харин тус орны зах зээлд ийм бүтээгдэхүүн нийлүүлэх явдлыг гадаадын компаниудад хөнгөвчилж өгөх учиртай. (ҮДК-ууд гаалийн өндөр хоригийг тойрч гарахын тулд ийм хөнгөлөлтийг хэрэглэдэг билээ Ц.Б).

**Төлбөрийн балансын харилцаа.** Дэлхийн зах зээлд Оросын оролцох оролцоо нь бараа, үйлчилгээний солилцоогоор хязгаарлагддаггүй, өөртөө валют-санхүүгийн болон зээлийн харилцаа, аялал жуулчлалын солилцоо, олон улсын хүн амын шилжилт хөдөлгөөн зэрэг олон асуудлыг багтаадаг учир энэ бүх төрлийн харилцан холбоо нь дэлхийн эдийн засгийн төлбөрийн болон хөрөнгө оруулалтын балансад төлөвлөрсөн журмаар илэрдэг бөгөөд энэ хоёр баланс нь дүн шинжилгээ хийх баялаг мэдээлэл өгдөг.

Жилээс жилд Орос орон бараа, үйлчилгээний тооцоо, түүнчилэн орж байгаа орлого, хөрөнгө оруулалтын орлогын төлбөр, хөдөлмөрийн хөлсийг тусган харуулдаг урсгал гүйлгээний дансаар томхон ашигтай сальдотой гардаг. 2000 онд энэ сальдо 46,3 тэрбум доллар буюу ДНБ-ий 19% болж байв (солилцооны ханшаар тооцоолоход Ц.Б). Энэ нь улс оронд бүтээсэн үнэт зүйлсийн нэг хэсэг гадагш бодитойгоор гарч байна гэсэн хэрэг бөгөөд учир нь экспорт нь импортоос, орлого нь төлбөрөөс давах явдал нь улс оронд хилийн чанадад тавих зээлийн шаардлага бий болохоор тэнцвэрждэг.

Оросын экспортонд гаргаж байгаа эрдэс түүхий эдийн үнийн гадаад орчны өсөлтийн нөлөөгөөр 2002 оноос улсын төсөв алдагдалгүй болсон. 2004 оноос эхлэн Нөөцийн сан гээчийг байгуулан энэхүү гэнэтийн орлогыг татан төвлөрүүлэх шийдвэр гаргасан нь богино хугацаанд амжилт олж, бусад улс оронд туршлага болох хэмжээнд хүрчээ. 2005 онд 647 тэрбум рубльтэй тэнцэх хэмжээний гадаад өрийг энэ данснаас төлсөн хэдий ч цаана нь 2,3 их наяд рубль буюу 80 гаруй тэрбум ам.долларын үлдэгдэлтэй байгаа аж. Оросын эдийн засаг, санхүүгийн салбар гадаад эдийн засгийн хүчин зүйлээс ихээхэн хамаардаг нь тогтворжуулах санг байгуулах урьдач нөхцөл болжээ. 2005 оны үзүүлэлтээр хий, нефть олборлолт, боловсруулалт, олборлолт, тээвэрлэлт, борлуулалт ДНБ-ий 26%, нүүрс-устөрөгч экспортын 59%-ийг бүрдүүлжээ. Иймээс эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын түвшин, инфляци, валютын ханшны динамик, үйлдвэрийн газрын санхүүгийн ажиллагааны дүн гэх мэт эдийн засгийн үндсэн үзүүлэлт гадаад эдийн засгийн үнээс ихээхэн ихээхэн хамаарахад хүргэж байна. “Түүхий эдийн” орлогоос төсвийн хамаарал их хэвээр байгаа өнөөгийн нөхцөлд Оросын эдийн засаг амжилттай хөгжсөнийг судлаачид онцгой тохиолдол гэж

үздэг. Учир нь Аргентин, Венесуэль зэрэг зарим оронд иймэрхүү шалтгаанаас үүдэлтэй санхүүгийн ийм хямрал үргэлжилсээр байна. Төлбөрийн тэнцлийн урсгал гүйлгээний дансны үлэмж хэмжээний илүүдэл сүүлийн хэдэн жилд дундажаар 10%-д хүрчээ. Энэ нь рублийн чангаралтаас сэргийлсэн бодлого хэрэгжүүлж байгаа Оросын Төв банкны валютын нөөцийг үлэмж нэмэгдүүлж, мөнгөний нийлүүлэлтийг өсгөхөд хэрхэн нөлөөлж буйг дараах хүснэгтээс үзнэ үү.

### Хүснэгт 10. ОХУ-ын мөнгөний нийлүүлэлт, төлбөрийн тэнцлийн сүүлийн 7 жилийн үзүүлэлт

	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Урсгал гүйлгээний дансны сальдо, ЛНБ-д харьцуулсан хувиар	12.6	18	11.1	8.5	8.3	10.3	11.4
Валютын нөөцийн өсөлт, тэрбум ам.доллар	1.8	16	8.2	11.4	26.4	45.2	57.7
Мөнгөний өсөлт, хувиар	54.1	60.2	38.1	30.4	49.6	24.9	31.7
Инфляци, хувиар, 12-р сар/12-р сар	36.5	20.2	18.6	15.1	12	11.7	10.9
Рублийн долларт харьцах бодит ханшны өсөлт, 12-р сар/12-р сар	13.2	14.2	8.0	-2.3	4.1	-4.7	10.5
Рублийн доллартай харьцах бодит ханшны өсөлт, хувиар 12-р сар/12-р сар	0.9	11.3	8.6	6.2	18.9	14	3.9

Эх сурвалж: “Вопросы экономики” сэтгүүлийн 2006. №2

Урсгал гүйлгээний дансны асар их актив бүхий Оросын төлбөрийн баланс нь гадаад эдийн засгийн харилцаа оновчтой болохыг харуулж чадахгүй байна. Нэлээд хэмжээний хасах сальдо ч уршигтай нь мэдээж. Учир нь гадаадаас зээл, хөрөнгө авч, өөрөөр хэлбэл өрөнд унан байж, энэ сальдог дарахад хүрэх нь мэдээж. АНУ жишээ нь урсгал гүйлгээний дансны ужиг пассивтай байдаг бөгөөд өөрөөр хэлбэл материалын болон бусад зүйлийг экспортлохоосоо илүү тэдгээрийг гаднаас импортлодог. Ингэснээр тус улс дотоод хэрэглээний томоохон нэмэлт нөөц бий болгодог. Гэвч ингэснээр асар их гадаад өр хуримтлагдаж, энэ өрийг эрт, орой нэгэн цагт хүүний хамт буцааж өгөхөд хүрнэ. Харамсалтай нь Орос орон ч нөөцөө доллараар хадгалж, дотоодын эргэлтэд долларын банкоматыг хэрэглэн, АНУ-д зээл олгоход аяндаа урсгалаар оролцож байдаг аж. Гэтэл хөрөнгө оруулах, хүн амын хэрэглээг өргөжүүлэх мөнгө Орост өөрт нь ус агаар мэт хэрэгтэй байдаг. Ийм л зөрчилтэй дүр зураг өнөө ч хэвээр үргэлжилж байна.

Шинэтгэлийн жилүүдэд Орост олгож буй зээлийн нэг адил Орост оруулж байгаа шууд болон үнэт цаасны хөрөнгө оруулалт нь тус орноос

капитал гаргахаас нэлээд бага байдаг аж. Үүнээс гадна, Орос орны хэмжээнд гаднаас авч байгаа хөрөнгийг оновчгүй зарцуулах явдал их байдаг аж. Дэлхийн банкны дүгнэснээр, түүний зээл олгож буй төслүүдийн зөвхөн 3/1 нь л хангалттай биелдэг байна. Олон үйлдвэрт өөрийн хөрөнгөнөөс гаалийн татвар төлөх боломж байхгүй учир эдгээр үйлдвэр зээлээр худалдаж авсан тоног төхөөрөмжөө авч чаддаггүй аж.

Зээлийг идэж барж, холбооны улсын болон бүс нутгийн төсвийн цоорхойг нөхөж ирсэн бол үнэт цаасны хөрөнгө оруулалт нь багагүй хэмжээгээр дамын наймааны шинж төрхийг өөртөө агуулдаг. Тиймээс эдийн засгийн бодит секторын хөгжилд оруулж буй гадаадын шууд хөрөнгө оруулалт тэнцвэргүй өчүүхэн хэсгийг эзэлсэн хэвээр байна. Тухайлбал, хуримтлагдсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ (гол дулааны цахилгааны цогцолбор, экспортод ажилладаг бусад салбар, түүнчилэн хүнсний аж үйлдвэр, худалдаанд) 2000 оны нэгдүгээр сарын 1-ний байдлаар 13 тэрбум ам.доллар байсан нь шилжилтийн эдийн засагтай бусад орон, жишээлбэл Хятад, Унгар, Польшийн хэмжүүрээр харьцуулан авч үзвэл үнэхээрийн бага.

**Гадаад өрийг зохицуулах асуудал.** Орос улс хуучин Зөвлөлт Холбоот Улсын болон өөрийн аль алиных нь томхон гадаад өрийг үүрч байгаа орны хувиар дэлхийн эдийн засагт оролцож байна. Гэтэл үнэндээ тус улс дэлхийн бусад хэсэгт зээл олгогч бөгөөд учир нь Оросын эрх залгамжлагч болсон Зөвлөлт Холбоот Улсын олгосон зээл, капиталын нийт хэмжээ нь Оросын өрийн үүргээс хавьгүй их байгаа юм. Гэтэл энэ мөнгийг бүрэн хэмжээгээр буцааж авч чадахгүй байна. Олон зээл найдваргүй болж, бүрэн юмуу заримыг нь хүчингүй болгож буй аж. Гарал үүслээрээ эргэлзээтэй гадагш гарсан капиталын тухайд гэвэл, өршөөл зарлаад ч түүнийг бүрэн буцааж авна гэж найдахад хэцүү болжээ.

Орост шилжиж ирсэн хуучин Зөвлөлт Холбоот Улсын өрийн барагцаалбал 68 тэрбум долларын өр нь үндсэндээ 80-аад онд, ялангуяа өөрчлөн байгуулалт эхэлсэн сүүлийн хагаст нь үүсчээ. Үүнээс гадна, бүр зөвлөлтийн үед үүссэн үйлдвэр, байгууллагуудын 35 тэрбум орчим долларын гадаад худалдааны өр байсан бөгөөд энэ өрийг Оросын улсын өрөнд шилжүүлсэн байдаг. Тийнхүү, зөвлөлтийн 100 тэрбум гаруй ам.долларын өрийн нийт үүрэг Оросын төсөвт бууж иржээ. Зөвлөлт Холбоот Улсыг тарж бутарсаны дараа Оросын засгийн газрын өөрийнх нь өр үүн дээр мэдээж нэмэгдэж таарна. Энэ өр 2000 он гэхэд 50 тэрбум орчим ам.доллар (10 улсын дотоодын үүргээр резидент биш этгээдүүдэд төлөх 11 тэрбум ам.долларыг тооцолгүйгээр - Ц.Б), түүний

дотор Олон улсын валютын сан, Дэлхийн банкинд 25 тэрбум ам.долларын өртэй. Эдийн засгийн эрс шинэтгэл хийсэн шинэ эрх баригчид зах зээлд шилжих шилжилтийн нийгмийн хурц сөрөг үр дагаварыг гадаад зээлийн тусламжтайгаар зөөлрүүлэхийг оролдож, ирээдүйд өрийг төлөх асуудлыг бодолхийлж байсангүй. Гэвч удалгүй энэ асуудал гарч ирж сөхөгдөн, засгийн газрыг зээлдүүлэгчидтэй хэлэлцээ хийхэд хүргэсэн аж

Парис, Лондоны клубуудтай хамтран Оросын өрийг хойшлуулах тухай тохиролцоо зарим талаар хөнгөвчилсөн хэдий ч, өр төлөх асуудал эдийн засгийн хувьд хүчрэхийн аргагүй ачаалал болж үлдсэн аж. 1994-1998 онд гэхэд л үүнд 34 тэрбум гаруй доллар төлсөн, харин дараа дараачийн жилүүдэд жил бүрийн төлбөр 13-14 тэрбум доллар болсон бөгөөд ингэхдээ оргил цэг нь 2003 онд таарч, тэгэхэд бараг 18 тэрбум доллар төлөх хэрэгтэй болжээ. Чухам тэр үед л Монголын өрийг төлүүлэх асуудал хүчтэй хөндөгдсөн.

90-ээд оны туршид гадаадын зээл нь улсын төсвийн цоорхойг нөхөж, түүнчилэн гадаад өр төлөхөд явж байв. Валют болон банкны систем сүйрэхээс сэрэмжлэхийг оролдон, аврах цагирагийн хувиар 1998 онд ийм зээл авч байжээ. Орос орон олон улсын валютын сангаас авсан 4,5 тэрбум ам.долларын зээлийг нүд ирмэхийн зуур үрсэн боловч рублийн ханшны навс уналтыг сэрэмжилж чадаагүй билээ.

Гадаад өрийн дарамт нь уг өрийг дарах ажлыг хөнгөвчлөхтэй холбоотой асуудлаар Оросын засгийн газрыг хэлэлцээ хийхэд хүргэсэн байна. Арилжааны банкууд өрийн зарим хэсгийг хүчингүй болгож, хойшлуулахаар Лондоны клубтэй тохиролцож чадсан байна. Гэвч Парисын клуб Оросыг угтан тоссон алхам хийж, засгийн газрын зээлийн төлбөрийн дарамтыг хөнгөвчилөхөд бэлэн байгаагаа харуулаагүй аж.

Орос улс шинэ зээл авах, хуучин өрийг зохицуулах асуудлаар тодорхой стратегигүй байв. Горбачевын өөрчлөн байгуулалтын үеийн адил, мөн дараа нь зах зээлийн эрс шинэтгэл хийж эхлэснээр дотоодын зах зээл болон улсын төсвийн байдал хэцүүдэж, сан хөмрөгт мөнгө хэрэгтэй болоход л гадаад зээл туйлын шаардлагатай болж иржээ. Энд гаднаас авсан хөрөнгийг хэрхэн илүү зохистой зарцуулах тухай бодох сөхөө тэр агшинд ч байхгүй байжээ. Өртэй хүн өгч амарна гэдгийг ч санах завдалгүй зарцуулж байжээ.

Мөнгөний байнгын хомсдол нь Оросын засгийн газрыг олж авсан мөнгөөрөө зээлдүүлэгч орноос бараа худалдаж авахыг зээлдэгчид үүрэг болгож байсан зээл олгох болзлыг зөвшөөрөхөд хүргэж байв. Элдэв

болзол тавьсан энэ зээл нь борлуулалтын нэмэгдэл зах зээл бий болгож, гадаадын үйлдвэрүүдэд ажлын байрыг хангаж өгч, гэхдээ Оросын үйлдвэрлэгчдээс олонхи нь гадныхнаас илүү бага үнээр адилхан бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадаж байсан хэдий ч, тэдэнд ийм боломж олгохгүй байв. Үүнээс гадна, болзол “тавьсан зээлүүд” нь худалдан авагчийг өрсөлдөгчдийн дундаас хамгийн ашигтай нийлүүлэгчийг сонгох давуу байдалгүй болгож, мэдээжийн дээгүүрдүүлсэн үнэ болон гэрээний бусад ашиггүй болзлыг зөвшөөрөхөд хүргэж байв.

Шинэтгэлийн жилүүдэд авсан Оросын гадаад зээлд дүн шинжилгээ хийж үзсэн судлаачид Оросын эдийн засагт гаднаас хөрөнгө оруулж байсан нь түүний өсөлтөд огтхон ч нөлөөлөөгүй гэсэн дүгнэлтэд хийсэн байна. Энэ талаар Ж.Сорос бүр ч шүүмжлэлтэй ханддаг. Тэрбээр Оросод очиж төрийн өндөрлөгүүдтэй уулзан зөвлөгөө өгсөн боловч талаар болсон. Ийм хандлага Монгол зэрэг шилжилтийн эдийн засагтай зээлдэгч оронд ч ажиглагдаж байгаа билээ. Мөнгийг үйлдвэрлэлийн хүчин чадал бий болгоход биш, харин тухайн үеийн хэрэглээ, улсын төсвийн цоорхойг нөхөхөд зориулж зээл авч ирсэн тул үйлдвэрлэл буурсаар байв. Туйлын хэр тааруухан шууд хөрөнгө оруулалтаас бусад зээлийн мөнгө нь тус орны экспортын бааз, түүний импортыг орлогч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд сулхан оролцож байсан бөгөөд сүүлийн хоёр зорилтыг хэрэгжүүлснээр л авсан зээлийг буцааж өгөх явдлыг хангаж чадах байсан гэж Оросын эдийн засагчид үзэж байна.

Зөвлөлт Холбоот Улсаас Оросын өвлөж үлдсэн бусад оронд олгосон зээлийн талаархи шаардлага нэлээдгүй их хэмжээтэй байгаа бөгөөд гэвч энэ мөнгийг буцааж авах нь бодож байснаас илүү асуудалтай болжээ. Зээлийг ЭЗХТЗ-ийн гишүүн улсууд, түүнчилэн зөвлөлтийн гадаад бодлого болон коммунизмын үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах найдлага бүхий хөгжиж буй ертөнцийн найрсаг орнуудад олгож байжээ. Энэ зээл нь нийлүүлж байсан аж үйлдвэрийн тоног төхөөрөмж болон техникийн тусламж, мөн зэвсэг, цэргийн техникийн (үлэмжхэн хэмжээтэй онцлов - Ц.Б) төлбөрийг хийхэд зориулж байв. Ингэхдээ улс төрийн шалтгаан нь зээл авагчид төлбөрийн чадварын тухай бодол санаа, өр буцаж төлөгдөхгүй байх эрсдлээс давамгайлж байжээ.

Варшавын гэрээний байгууллага, ЭЗХТЗ, дараа нь ЗСБНХУ ч тарж бутарч, улмаар Орос цэрэг, улс төрийн талаар суларсны дараа олон улсын тавцанд хүчний байршил үндсээрээ өөрчлөгдсөн нөхцөлд өртэй олон орон үүргээ цаг алдалгүй биелүүлэхээс татгалзахын тулд байдлыг далимдуулан, ерөөс өрийг бүрэн хүчингүй болгохыг шаардах

болсон. Тэдгээрээс олонхи нь яаж ч хүслээ гэсэн төлбөр хийх чадваргүй бөгөөд төлбөрийн балансын ужиг алдагдалтай ядуу, туйлын ядуу орнуудад хамаарагдаж байна.

Цөөхөн орон л, тэдгээрийн дотор юуны өмнө Монгол л өртэй гэдгээ бүрэн хүлээн зөвшөөрч, богино хугацаанд төлж барагдуулжээ. Бусад орнууд өртэй гэдгээ ч хүлээн зөвшөөрөөгүй байна. Учир нь социализмын үед хөгжиж байгаа орнуудад олгосон зээл улс төрийн бодлогоо хэрэгжүүлэх Оросын механизмын үүрэг гүйцэтгэдэг байсан гэж үздэг.

Олон улсын хамтын нийгэмлэгээс Ливи, Иракийн эсрэг хориг арга хэмжээ авсан нь эдгээр орны зүгээс үүргээ биелүүлэхэд саад болох болсон билээ. Өнөөдөр Орос өрийг валютаар биш, харин 90%-ийг нь тухайн орнуудын бараа юмуу бусад янз бүрийн аргаар төлж байгаатай эвлэрэхэд хүрч байна.

Бие даасан улсын хувьд Орос улс өөртэй нь хийж буй тооцоон дахь ТУХН-ийн бусад орны алдагдлыг уг нь төлөхийн тулд тэдгээрт зээл олгож байв. 1992-1993 онд энэ техникийн шинжтэй зээлийн хэмжээ бараг 5,3 тэрбум ам.доллар болж, ингэхдээ рублийн дүнг хөнгөлттэй ханшаар долларт шилжүүлж байв. Цаашид эдгээр зээлийг Орост ТУХН-ийн орнуудын төлөх улсын өр болгон өөрчилсөн юм. Үүнээс гадна, 1993 оны дундаас 2000 оны эх хүртэл эдгээр орон Оросын тодорхой нэрийн бараа авсаныхаа төлбөрийг хийж, Орост төлөх хугацаа хэтэрсэн өрийг зарим талаар санхүүжүүлэхийн тулд 900 сая ам.долларын зээл нэмж авчээ.

1998-2000 онд “тэглэх хувилбарын” үндсэн дээр зээлийн шаардлага, үүргийг зохицуулсан байна. Учир нь ТУХН-ийн олон орон 1991 онд гадаад эдийн засгийн банкинд өөрсдийнх нь валютын дансыг битүүмжилсэн (Азербайжан, Узбекистан, Туркменистан) юмуу цэргийн болон бусад объектийг түрээслэж (Казахстан, Беларусь, Гүрж), цэргийн техник (Гүрж), цөмийн зэвсгийг (Украин, Беларусь) гаргасантай холбогдуулан Орост хариу шаардлага тавьсан аж. Эдгээр орон Зөвлөлтийн өрийг зохицуулах тухай хэлэлцээрээр Орост шилжсэн гадаад дахь өр болон алмазын фонд дахь өөрийн тодорхой хувийг өгөхийг бас шаардсан байна.

Хэрвээ 90-ээд оны сүүлчээр улсын шугамаар Орост ТУХН-ийн орнуудын төлөх өр нэлээд багассан бол, харин Оросын хувийн аж ахуйн бүтэцүүд болон төсвийн байгууллагуудад төлөх энэ өр 2000 оны эх гэхэд 5,6 тэрбум доллар болж өссөн байна. Энэ өрийн ихээхэн

хэсэг нь Оросын байгалийн хий, цахилгаан эрчим хүчний экспорттой холбоотой бөгөөд ихэнхи нь Украинд ногдож байна.

Оросын гадаадаас авах өр болон гадаад дахь активын (гол нь 4,1 тэрбум доллароор үнэлэгдэж байгаа оросын өмчийг (Финансовые известия. 1999.04.08-ыг үз) удирдах нь эдийн засгийн бодлогын нэг тулгамдсан асуудал хэвээр байна. Энд сайтар нягтлан бодсон стратеги, түүнийг хэрэгжүүлэх уян хатан хэрэгсэл хэрэгтэй аж. Оросын улс ардын аж ахуй гадаад зээлийн болон сан хөмрөгийн өрийн ачааллын өөрийн гэсэн хязгаартай. Улсын гадаад өрийн хэмжээ ДНБ-ий хэмжээтэй бараг тэнцсэн бөгөөд гэтэл олон улсын шалгуураар өр нь ДНБ-ий талаас илүүгүй байж болно гэж үздэг. Эдийн засгийн жил тутмын эрүүл өсөлт 4-5% байх нөхцөлд 100-120 тэрбум долларын түвшинд байгаа өрийн үүргийн хязгаараас давж гарсан нь төсөв, дотоодын хөрөнгө оруулалтад ноцтой таагүй байдал бий болгох аюултай бөгөөд инфляцийг ихэсгэж, эцсийн дүнд ард түмний амьжиргааны түвшин доройтоход хүргэж болох юм. Өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл болон улс орны эдийн засгийн өсөлтийн хурдацад нөлөөлж, өр төлөхөд хангалттай орлогыг бүрдүүлж чадах дэд бүлгийн хөгжилд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь зээлийн хөрөнгийг татан авах нэг гол нөхцөл болох ёстой гэж судлаачид үзэж байна.